

2016 оны 9 дүгээр сарын 10-ний өдрийн бүх гишүүдийн хурлаар өөрчлөлт оруулав.

**"ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ЗӨВЛӨЛ" ТӨРИЙН
БУС БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ**

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Нийтлэг Үндэслэл

1.1. Байгууллага. Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл нь /цаашид Зөвлөл “ гэх/ дэлхий даяар тархан суугаа Монголчуудын хилийн чанадад байгуулсан төрийн бус байгууллагууд (цаашид "гишүүн байгууллагууд" гэх)-ын хамтын ажиллагааны нэгдэл

бөгөөд/ бөгөөд Монгол Улсын Төрийн бус байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллах төрийн бус байгууллага мөн.

1.2. Оноосон нэр.

Монголоор:

"Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл " ТББ

Англиар:

"Council of Mongolians Abroad"

1.3. Х

аяг.

Монго

л Улс

Улаанбаатар хот

Харилцах утасны дугаар: 99996779

И-мэйл хаяг: info@mongoliansabroad.org

1.4. Үүсгэн байгуулсан он сар өдөр, газар.

2014 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр.

Монгол Улс, Улаанбаатар хот

Гадаад Харилцааны Яамны хурлын танхим.

1.5. Эрх зүйн статус. Зөвлөл нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлтэй, өмчлөлдөө тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх хуулийн этгээдийн эрх зүйн чадамжтай байна. Зөвлөл нь өөрийн бэлгэдэл, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

1.6. Үндсэн зарчим. Зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах үндсэн зарчмыг удирдлага болгоно:

- 1) Хилийн чанад дахь Монголчуудын нийтлэг эрх ашгийг төлөөлнө;
- 2) Үйл ажиллагаагаа гишүүн байгууллагуудынхаа гаргасан санал, санаачлагын үндсэн дээр явуулна;
- 3) Гишүүн байгууллагынхаа үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, нөлөөлөхгүй;
- 4) Үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар удирдаж, явуулна;
- 5) Зөвлөлийн үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ.

Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Зорилго. Зөвлөл нь дараах зорилготой байна:

- 1) Хилийн чанадад байгуулагдсан ТББ ба Монгол Улсын хоорондох харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж, гүүр болон ажиллах,
- 2) Хилийн чанадад амьдарч буй үе үеийн Монголчуудынхаа нийгэмдээ дасан зохицож, нэр төртэй, сайн сайхан амьдарч, аж төрөхийг нь урамшуулан дэмжих,
- 3) Дэлхий даяар тархан суугаа Монголчуудын оюун санааны нэгдмэл байдлыг дэмжиж, шинжлэх ухаан, түүх, боловсрол, соёл, спортын зэрэг хүрээнд харилцан хамтын ажиллагааг нь өргөжүүлэн хөгжүүлэх,
- 4) Хилийн чанадад амьдарч буй Монголчууд, өсвөр үе, хүүхэд багачуудын Монгол хэл, түүх, зан заншил, өв соёл, уламжлалдаа суралцахыг нь дэмжих,
- 5) Гадаад улс, орнуудад Монгол Улсыг сурталчлан таниулах.

2.2. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 1) Гадаад улс, орны тэргүүн туршлага, дэвшилтэд технологийг Монголд нэвтрүүлэх зэрэг хилийн чанад дахь иргэдийнхээ эх орныхоо хөгжилд бодит хувь нэмэр оруулахуйц төсөл, санааг дэмжин ажиллах;
- 2) Зөвлөлийн зорилгод нэгдэж, өөрийн улс оронд явуулж буй үйл ажиллагаагаараа тэргүүлсэн гишүүн байгууллагуудыг урамшуулах, туршлагыг нь түгээх;
- 3) Хилийн чанад дахь Монголчуудын нийтлэг эрх ашиг, сонирхлыг нэгтгэн Монгол Улсын төрийн холбогдох байгууллагад төлөөлөн хүргэх, хамтран ажиллах;
- 4) Хилийн чанад дахь Монголчуудын талаар Монгол Улсын төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилтийн хүрээнд төрийн холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан, нягт хамтран ажиллах;
- 5) Монгол орноо сурталчлах;
- 6) Дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагуудыг нэн түрүүн дэмжин ажиллана. Үүнд:

i. Хилийн чанад дахь Монголчуудын мэдээлэл харилцан солилцоог дэмжих, мэдээлэл түгээх, нэгтгэх;

ii. Хилийн чанад дахь Монголчуудын дунд сургалт, чуулга уулзалт, уралдаан тэмцээн, соёлын арга хэмжээг зохион байгуулах;

iii. Хилийн чанадад амьдарч буй хойч үеийн Монголчууддаа Монгол хэл, өв соёл, уламжлалыг өвлүүлэх;

iv. Монгол орноо сурталчлах, таниулах;

Зөвлөл нь дээрх чиглэлийн хүрээнд явуулах үйл ажиллагаагаа жил бүрийн хөтөлбөрт тусган баталснаар хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ.

Гишүүнчлэл

3.1. Гишүүнчлэл. Зөвлөл д түүний зорилго, үзэл санаа, үйл ажиллагааг зөвшөөрч, дэмжиж буй төрийн бус байгууллага гишүүнээр элсэн орж болно.

Гишүүнчлэл нь дараах 2 төрөлтэй байна:

- 1) Энгийн гишүүн – хилийн чанад дахь Монголчуудын төрийн бус байгууллага;
- 2) Хүндэт гишүүн – хилийн чанад дахь Монголчуудыг дэмжиж ажилладаг бусад төрийн бус байгууллагууд.

3.2. Гишүүн элсүүлэх, бүртгэл. Зөвлөлд гишүүн элсүүлэх асуудлыг Удирдах Зөвлөл хариуцаж, гишүүний бүртгэл хөтөлнө.

3.3. Энгийн гишүүн. ТББ нь гишүүн болох хүсэлтээ албан ёсоор ирүүлсэний дагуу Удирдах зөвлөл хүлээн авч тогтоол гаргаснаар түүнийг Зөвлөлийн гишүүн-байгууллагад тооцно. Гишүүн байгууллага нь Зөвлөлийн гишүүний хураамж төлөх ба тэрээр энэхүү хураамжийг төлснөөр саналын эрхээ эдэлнэ.

3.4. Хүндэт гишүүн. Хилийн чанад дахь Монголчуудыг дэмжиж ажилладаг энгийн гишүүнээс бусад төрийн бус байгууллагыг Зөвлөлийн Удирдах зөвлөлийн урилгаар хүндэт гишүүнээр элсүүлж болно. Хүндэт гишүүн нь Зөвлөлийн гишүүний хураамжаас чөлөөлөгдөх ба чуулганд саналын эрх эдлэхгүй.

3.5. Зөвлөлийн гишүүн-байгууллагын үүрэг, эрх, хариуцлага.

- 1) Гишүүн байгууллага нь Зөвлөлөөс явуулж буй үйл ажиллагаанд эрх тэгш оролцох, мэдээлэл авах эрхтэй.
- 2) Гишүүн байгууллага нь Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалд хүсэлт гаргах, санал оруулах эрхтэй.
- 3) Гишүүн байгууллага нь Зөвлөлийн үйл ажиллагааны явцад хяналт тавих үүрэгтэй.
- 4) Гишүүн байгууллага төрийн бус байгууллага байхаа болих, эсхүл энэхүү дүрмийг зөрчсөн болон гишүүн байгууллага өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд түүний гишүүнээс хасах хүртэл шийдвэрийг Удирдах Зөвлөлийн хурлаар гаргана.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.

Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Зөвлөлийн удирдлага нь Зөвлөлийн чуулган, Удирдах зөвлөл, Төлөөлөгчидийн зөвлөл, гүйцэтгэх ба хяналтын албанаас бүрдэнэ.

4.2. Зөвлөлийн эрх барих дээд байгууллага нь чуулган /цаашид “Чуулган” гэх/ байна.

4.3. Чуулганаар хэлэлцэх асуудал. Зөвлөлийн ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ:

- 1) Зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах,
- 2) Удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, эгүүлэн татах,
- 3) Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилох, эгүүлэн татах,
- 4) Зөвлөлийн өмнөх жилийн ажлын тайланг хэлэлцэн батлах,
- 5) Зөвлөлийн ирэх жилийн ажлын хөтөлбөрийг батлах,
- 6) Чуулганаар шийдвэрлүүлэхээр Удирдах зөвлөлөөс оруулсан бусад асуудал.

4.4. Чуулганы зохион байгуулалт. Чуулганыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна. Чуулганы зарыг хурал болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүн-байгууллагуудад тараана. Хэрэв Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэсэн бол ээлжит бус Чуулганыг шийдвэр гаргаснаас хойш 60 хоногийн дотор зарлан хуралдуулж болно. Чуулганы хуралдааныг тодорхой газарт товлон зохион байгуулахаас гадна чуулганд оролцогсад бие биенээ нэгэн зэрэг сонсч, харж, ярилцах боломжтой тохиолдолд цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

4.5. Чуулганы ирц, санал хураалт. Чуулганд оролцвол зохих нийт гишүүн байгууллагуудын олонхи оролцсоноор Чуулганыг хүчинтэйд тооцно. Чуулганыг Удирдах зөвлөлийн дарга удирдана. Чуулганаар хэлэлцсэн асуудлыг чуулганд оролцож буй гишүүн байгууллагуудын олонхийн саналаар шийдвэрлэнэ. Чуулганд гишүүн байгууллага бүр тэгш эрхтэй оролцох ба нэг гишүүн байгууллага нэг саналын эрхтэй. Чуулган оролцоогүй гишүүн байгууллагын өмнөөс төлөөлөх санал тоолуулахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ.

Удирдах зөвлөл

5.1. Удирдах зөвлөл. Чуулганы хооронд Зөвлөлийн эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ байна.

5.2. Удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн. Удирдах зөвлөл нь 5-аас доошгүй, 15-ээс дээшгүй сондгой тооны гишүүдээс сонгоно.

5.3. Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох. **Чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар төлөөлөгчдийн зөвлөлөөс дараах байдлаар сонгоно.**

Үүнд: Холбоо, үйл ажиллагааны чиглэл болон улс орны харьяалалаас үл хамааран 5-11 гишүүн, мөн үндсэн чиглэлийн хороодын дарга нар нийт 15 хүртэлх тооны сондгой тооны гишүүн байна.

Төлөөлөгчдийн зөвлөлд 6 сараас дээш хугацаагаар идэвхтэй ажилласан гишүүн УЗ-д нэр дэвшигдэх эрхтэй. Гишүүдийн бүрэн эрхийг хугацаа 2 жил байх бөгөөд улиран сонгогдож болно.

5.4. Удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх.

- 1) Удирдах зөвлөлийн гишүүн нь биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон бол албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ Тэргүүн, улмаар Удирдах зөвлөлд мэдүүлж болно.
- 2) Удирдах зөвлөлийн гишүүн Зөвлөлийн бодлого, үйл ажиллагааны асуудлаар санал зөрсөн зэргээс үүрэгт ажлаа хэрэгжүүлэх боломжгүй болсон бол албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Тэргүүн, улмаар Удирдах зөвлөлд хэдийд ч гаргаж болно.
- 3) Зөвлөлийн дүрмэнд харшлах үйлдэл хийсэн Удирдах зөвлөлийн гишүүнийг Удирдах зөвлөлөөр хэлэлцэн үүрэгт ажлаас чөлөөлж болно.
- 4) **Хагас жилээс дээш хугацаагаар үйл ажиллагаанд оролцоогүй Удирдах зөвлөлийн гишүүнийг Удирдах зөвлөлөөр хэлэлцэн үүрэгт ажлаас чөлөөлж болно**
- 5) Дээрх үндэслэлээр Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх шийдвэрийг Тэргүүн гаргана. Чөлөөлөгдөж буй Удирдах зөвлөлийн гишүүний оронд Удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлж Тэргүүний батламжилсан хүнийг **Төлөөлөгчдийн зөвлөлөөс нөхөн томилох** ба тэрээр чөлөөлөгдсөн гишүүний үлдсэн хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

5.5. Удирдах зөвлөлийн бүрэн эрх. Зөвлөлийн Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1) Зөвлөлийн үйл ажиллагааны богино, дунд хугацааны бодлого, зорилтыг тодорхойлох;
- 2) Зөвлөлийн үйл ажиллагааны жил тутмын Хөтөлбөрийг боловсруулж, Чуулганаар батлуулах, ийнхүү батлагдсан Хөтөлбөрийг Монгол Улсын төрийн холбогдох байгууллагад танилцуулж, хамтран ажиллах;
- 3) Зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Чуулганд оруулж, шийдвэрлүүлэх;
- 4) Зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг жил бүрээр батлан төсвийн хэрэгжилтийн тайлан болон Хяналтын зөвлөлийн дүгнэлтийг Чуулганд танилцуулах;

- 5) Зөвлөлийн гишүүний хураамжийн хэмжээг тогтоох;
- 6) Монгол Улсын төрийн холбогдох байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хөтөлбөрийг батлах;
- 7) Зөвлөлийн Тэргүүнийг томилох, түүний үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллах;
- 8) Удирдах зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргыг Тэргүүний санал болгосоноор томилох. Ерөнхий нарийн бичгийн даргын ажил үүргийн хуваарь, эрх хэмжээг Удирдах зөвлөлөөс тогтоож өгнө.
- 9) Зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө татах, босгох, хуримтлуулах талаар идэвх, санаачилгатай ажиллах;
- 10) Зөвлөлийн гишүүн-байгууллагуудтай тогтмол холбоотой байж, тэдний дуу хоолой, санал, санаачилга, хүсэлтийг үйл ажиллагааны Хөтөлбөрт тусгах, тухайн цаг үеийн эрх ашиг, сонирхлын нийтлэг асуудлаар Монгол Улсын төрийн холбогдох байгууллагад Тэргүүнээр дамжуулан хандах;
- 11) Зөвлөлийн нэр хүндийг эрхэмлэж өндөрт авч явах;
- 12)) Удирдах зөвлөлийн олонхиор шийдвэрлэсэн бусад асуудал.

5.7. Удирдах зөвлөлийн хурлын зар. Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улирал тутамд хийнэ. Шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийн дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлын зарыг хурал болохоос нэг 7 хоногоос доошгүй хугацааны өмнө урьдчилан тараах ба энэхүү зард хурлаар хэлэлцэх асуудлыг хавсаргасан байна.

5.8. Удирдах зөвлөлийн хурлын хүчин төгөлдөр байдал. Удирдах зөвлөлийн хуралд 7 -аас доошгүй гишүүн оролцсоноор хурлын ирц бүрдсэнд тооцно. Хурлыг харилцан нэгнээ сонсох, ярилцах боломжтой тохиолдолд цахим хэлбэрээр хийж болно. Удирдах зөвлөлийн хурлыг цахим хэлбэрээр хийх журмыг Удирдах зөвлөлөөс батална.

5.9. Удирдах зөвлөлийн шийдвэр гаргах. Удирдах зөвлөлөөр хэлэлцсэн асуудлаар хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Нэг гишүүн саналын нэг эрх эдэлнэ. Хэрэв санал тэнцсэн бол Удирдах зөвлөлийн дарга таслах шийдвэр гаргана.

5.10. Удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал. Удирдах зөвлөлийн гишүүд нь Зөвлөлийн зорилго, хөтөлбөр, үйл ажиллагааг сайн дураар дэмжин ажиллаж байгаа ба ямарваа цалин, хөлс авахгүй. Харин тэдний Чуулган ба Удирдах зөвлөлийн хуралд биеэр оролцохтой холбогдуулж хувиасаа гаргасан бодит зардлыг

бүрэн буюу хэсэгчлэн нөхөн төлж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

Төлөөлөгчидийн зөвлөл

6.1. ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛ- ийн бүтэц. улс орон бүрээс монголчуудын тоо, үйл ажиллагаа явуулж буй холбоодын тооноос хамааран 33 гишүүнтэй байна.

6.2. ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛ- ийн Зорилго. Зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнтэй оновчтой явуулахад бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах, зөвлөлийн удирдлагад цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх.

6.3. ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛ- ийн Үйл ажиллагаа.

- 1) Зөвлөлийн үр дүнтэй ажиллагааг хангах, судалгаа, мэдээлэл хийх;
- 2) Г ишүүн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, дэмжих, төлөөлөх;
- 3) Зөвлөлийн удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

6.4. ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛ сонгох -

6.5. /ээлжит хурал 3 сар тутамд/

ДОЛООДУГААР ЗҮЙЛ.

Гүйцэтгэх алба

7.1. Бүтэц

Удирдах зөвлөлийн хурлаар гүйцэтгэх албыг бүрдүүлэх ба дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 1) Зөвлөлийн тэргүүн бөгөөд Удирдах зөвлөлийн дарга
- 2) Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга
- 3) Санхүүгийн асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн
- 4) Гишүүнчлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн

5) Хороод, хөтөлбөрийн асуудал хариуцсан удирдах зөвлөлийн гишүүн

Эдгээр албан тушаалын орон гарсан тохиолдолд Удирдах зөвлөлийн шийдвэрээр нөхөн сонгоно.

7.2. Зөвлөлийн тэргүүн

Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Тэргүүн удирдах ба Удирдах зөвлөлийн дарга нь Зөвлөлийн Тэргүүн байна. Тэргүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1) Зөвлөлийг төлөөлж бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;
- 2) Удирдах зөвлөл болон Хороодын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих;
- 3) Удирдах зөвлөлийн хурлыг улирал тутам зохион байгуулах;
- 4) Зөвлөлийн Чуулган ба Удирдах зөвлөлийн хурлыг даргалах;
- 5) Удирдах зөвлөлийн эрх олгосноор Зөвлөлийг төлөөлж гадаад, дотоодын аливаа байгууллагатай гэрээ, хэлэлцээ байгуулах;
- 6) Зөвлөлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт, хамтран ажиллах асуудлаар Монгол Улсын Гадаад харилцааны яамтай шууд харилцах;
- 7) Орон тооны болон түр зөвлөхүүдийг авч ажиллуулах;
- 8) Удирдах зөвлөлийн олгосон бусад бүрэн эрх.

7.3. Ерөнхий нарийн бичгийн дарга. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Удирдах зөвлөлөөс тогтоосон ажил үүргийн хуваарь, эрх хэмжээний дагуу ажиллана.
- 2) Тэргүүний шууд удирдлагад ажиллаж, түүний бодлогыг хэрэгжүүлэгч гол албан тушаалтан байх,
- 3) Зөвлөлийн Тэргүүнийг эзгүйд бүрэн эрхийг нь Ерөнхий нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.
- 4) Байгууллагын захиргаа, бичиг хэргийн асуудлыг хариуцан эрхлэх, түүний хадгалалт хамгаалалтын асуудлыг хариуцах,
- 5) Нийт гишүүдийг Нэгдсэн хуралдаан болон Удирдах зөвлөлийн хурлын талаарх болон зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангаж ажиллах,

НАЙМДУГААР ЗҮЙЛ.

Хяналтын алба

8.1. Хяналтын алба нь Зөвлөлийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд явагдаж байгаа эсэхэд болон байгууллагын хөрөнгө, санхүүгийн байдалд хяналт шалгалт хийх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Хяналтын алба нь Зөвлөлийн санхүүгийн байдалд хийсэн шалгалтын тайланг жил тутамд Чуулганд танилцуулж байна.

8.2. Хяналтын алба нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байх ба Чуулганы гишүүд дотроос **3 жилийн хугацаагаар томилно**. Удирдах зөвлөлийн гишүүн Хяналтын албаны гишүүн байхыг хориглоно.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.

Хороод ба алба

9.1. Зөвлөл гишүүдийнхээ эрх ашиг, сонирхлын нийтлэг асуудлаар хөтөлбөрийн хүрээнд ажиллах дараах байнгын хороод, албатай байна:

- 1) Боловсролын хороо
- 2) Соёл, урлаг, спортын хороо
- 3) Бизнес хөгжлийн хороо
- 4) Оюутан, залуучуудын хороо
- 5) Мэдээлэл, харилцааны алба

9.2. Хороо, албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг Зөвлөлийн үйл ажиллагааны хөтөлбөрт нэгтгэн тусгана.

9.3. Шаардлагатай тохиолдолд цаг үеийн эрэлт, гишүүн-байгууллагуудын хүсэлт, хэрэгцээг үндэслэн Удирдах зөвлөлтэй хийсэн гэрээний үндсэн дээр түр хороог байгуулж болох ба уг хороо нь өмнөө тавьсан зорилгоо биелүүлмэгц татан буугдана. Түр хорооны дарга нь Удирдах зөвлөлийн гишүүн байх шаардлагагүй.

9.4. Зөвлөлийн байнгын ба түр дэд хороод нь Зөвлөлийн гишүүн-байгууллагуудын холбогдох асуудлаарх сонирхол, эрх ашгийг нэгтгэж, тэдний хоорондын ажлын уялдаа холбоог зохицуулж, эдгээр гишүүн-байгууллагуудын тэргүүн туршлага, бүтээгдэхүүн, үйлчилгээг зохих гэрээ, зөвшилцлийн дагуу дэлхий даяар тархан

суугаа Монголчуудын хүртээл болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана.

9.5. Байнгын хороод нь үйл ажиллагаагаа Удирдах зөвлөлийн хуралд тайлагнах ба Удирдах зөвлөл нь байнгын хороодын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог хангах, байнгын хороодоос гарсан саналыг Зөвлөлийн жилийн Хөтөлбөрт тусгах, гүйцэтгэлийг нь хянан хэрэгжилтэд нь бүх талын туслалцаа үзүүлэн ажиллах үүрэгтэй.

АРАВДУГААР ЗҮЙЛ.

Санхүү, төсөв

10.1. Зөвлөлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 1) Гишүүний хураамж
- 2) Хандив, тусламж
- 3) Тэтгэлэг
- 4) Монгол Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
- 5) Зорилгодоо чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулсанаас олсон орлого.

10.2. Зөвлөлийн санхүүгийн жил нь хуанлийн жилтэй адил байна.

10.3. Зөвлөл д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ажилтнуудын цалин, хөлсийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.

Бусад зүйл.

11.1. Гишүүн-байгууллагад хүлээлгэх хариуцлага. Энэхүү дүрэм болон Удирдах зөвлөлөөс тогтоосон журмыг удаа дараа зөрчиж, Зөвлөлийн зорилго, үйл ажиллагааг эсэргүүцэн, байгууллагын нэр хүндийг гутаах үйл ажиллагаа явуулсан гишүүн-байгууллагад эрхийг нь түдгэлзүүлэх, улмаар гишүүнээс хасах хүртэл хариуцлага ногдуулна.

11.2. Зөвлөлийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах.

- 1) Зөвлөлийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай асуудлыг Удирдах Зөвлөлийн саналын дагуу Чуулганаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Энэ асуудлыг Чуулганд оролцогч гишүүн-байгууллагуудын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Чуулганы шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

2) Хэрэв Чуулганаас Зөвлөлийг татан буулгах шийдвэр гаргасан бол холбогдох хууль тогтоомж, журмын дагуу татан буулгалтын комисс томилж, татан буулгах ажиллагааг хийх ба бусдад төлбөл зохих өр төлбөрийг гүйцэтгээд үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

11.3. Хүчин төгөлдөр болох. Энэхүү дүрэм нь баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.